



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 4/05

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Баярсайханы Нандин-Эрдэнэ (СЖ92070517)-ийн хүсэлтийг судлан үзээд, Цэнхэрмандал сумын 1 дүгээр баг Хужхан, Цэнхэр гол гудамж, 4 тоот хаягт байрлах, 2321001865 нэгж талбарын дугаартай, худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалттай 350 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Өлзийбатын Лхагважав (HE77011463)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан иргэн Б.Нандин-Эрдэний эзэмшлийн 0000181738 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

